ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
48090 Мандалговь, Сайнцагаан сум
Утас: 70592439, 70592208, 70593208
Е-мэйл: dundgovi@audit.gov.mn

2020.07.30 № 81

танай ______ -ны № ______ -т

ХӨДӨЛМӨРИЙН ҮНДЭСНИЙ НАМД

Хандивын тайлангийн дүгнэлт

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Хөдөлмөрийн үндэсний намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

***Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл***

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Хөдөлмөрийн үндэсний нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

***Дүгнэлтийн үндэслэл***

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Хөдөлмөрийн үндэсний намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

0012020394

*Дүгнэлт*

**ХӨДӨЛМӨРИЙН ҮНДЭСНИЙ НАМ** нь 2020 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацааны хандивын тайланд тусгасан нийт нэг сая есөн зуун гучин мянган төгрөгийн хандивыг Улс төрийн намын тухай хуулиар тавьсан шаардлагын дагуу хүлээн авсан байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ТӨВСАНАА

**Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам, эвсэлд "ХУУЛИЙН ЭТГЭЭД"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт**

**ХӨДӨЛМӨРИЙН ҮНДЭСНИЙ НАМ /намын нэр/**

/мян.төг/

| Д/д | Хуулийн этгээдийн нэр | Хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээлэл | | | | | Хандив хүлээн авсан | | | Мөнгөн дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Регистрийн дугаар | Хаяг, утасны дугаар | Үүсгэн байгуулагдсан огноо | Үйл ажиллагааны чиглэл | Хуулийн этгээдийн хэлбэр | Огноо | Банкны нэр | Дансны дугаар | | |
| Ээлжит сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон | | | | | | | | | | | |
| 1 | x | x | x | x | x | x | x | x | x | 0 | x |
| 2 | x | x | x | x | x | x | x | x | x | 0 | x |
| Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд | | | | | | | | | | | |
| 1 | x | x | x | x | x | x | x | x | x | 0 | x |
| 2 | x | x | x | x | x | x | x | x | x | 0 | x |

Мэдээллийг бэлтгэсэн: Хөдөлмөрийн Үндэсний Намыг төлөөлж

Нам /эвслийн/ нэр

(тэмдэг)___Ерөнхий Нарийн Бичгийн Дарга — Доноровын Гантулга — [signature]

албан тушаал — овог нэр — гарын үсэг

УЛААНБААТАР ХОТ ХӨДӨЛМӨРИЙН ҮНДЭСНИЙ НАМ 8488100 1117243465

**Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам, эвсэлд "ИРГЭН"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт**

**ХӨДӨЛМӨРИЙН ҮНДЭСНИЙ НАМ /намын нэр/**

/мян.төг/

| Д/д | Иргэний овог нэр | Хандив өгсөн иргэний мэдээлэл | | | | Хандив өгсөн огноо | Хандив өгсөн дүн | Хандив хүлээн авсан | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Регистрийн дугаар | Нас | Оршин суугаа хаяг | Утасны дугаар | | | Банкны нэр | Дансны дугаар | |
| Ээлжит сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон | | | | | | | | | | |
| 1 | x | x | x | x | x | x | 0 | x | x | x |
| 2 | x | x | x | x | x | x | 0 | x | x | x |
| Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд | | | | | | | | | | |
| 1 | x | x | x | x | x | x | 0 | x | x | x |
| 2 | x | x | x | x | x | x | 0 | x | x | x |

Мэдээллийг бэлтгэсэн: Хөдөлмөрийн Үндэсний Намыг төлөөлж

Нам /эвслийн/ нэр

УЛААНБААТАР ХОТ XYII ХӨДӨЛМӨРИЙН ҮНДЭСНИЙ НАМ

(тэмдэг)___Ерөнхий Нарийн Бичгийн Дарга
албан тушаал

Доноровын Гантулга
овог нэр

гарын үсэг